



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/94


Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/829 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/52 дугаар тушаалаар батлагдсан Баянзүрх дүүргийн гэр хорооллын айл өрхийн нохойг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд нохойны паспорт хэвлүүлэх, нохойны хүзүүвч, пайз хийлгэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий Менежерийн
2019 оны 04 сарын 09 өдрийн
тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Б.Мөнхбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Халиун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тооцооны нягтлан бодогч
	А.Нямдорж	Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн төрийн бус байгууллагын тэргүүн /Зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Т.Энх-Амгалан	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн